



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
МЕНЕЖМЕНТ ҮЦЦ ХХК

ЖИЛИЙН ТАЙЛАН 2022





I БҮЛЭГ

АГУУЛГА

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС, БОДЛОГО
САНГУУДЫН ТАНИЛЦУУЛГА, ГҮЙЦЭТГЭЛ

ХОЁР. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
КОМПАНИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ГУРАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЙЛАН
ЗАСАГЛАЛЫН КОДЕКС
ISO 9001:2015 , MS 365 НЭВТРҮҮЛЭХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТОГТВОРТОЙ БАЙДАЛ-БОНЗ
САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР
ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО
ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА
ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ



АЛСЫН ХАРАА

Нийслэлийн тогтвортой хөгжил, хөрөнгө оруулалтын ашигт байдлыг эрхэмлэнэ.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Нийслэлд шинийг санаачлагч, тогтвортой хөгжлийг дэмжигч, салбартаа тэргүүлэгч компани болох

ЧАНАРЫН БОДЛОГО

Нийслэл болон гадаад, дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчидтай хамтран байгальд ээлтэй, бүтээн байгуулалтыг дэмжсэн, инновацлаг төсөл хөтөлбөрүүдийг эрсдэлд суурилан хэрэгжүүлэх замаар хөрөнгө оруулалтын ашигт байдлыг нэмэгдүүлж компанийн менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулна.

ҮНЭТ ЗҮЙЛС



Мэргэжлийн
ёс зүй



Мэргэшсэн
хамт олон



Хамтын
ажиллагаа



Бүтээлч
сэтгэлгээ



Мэдээллийн ил тод
байдал



САНГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛ

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН САН

Нийт активын хэмжээ: 2,084,067,071.33 ₮

2022 оны гүйцэтгэл:



Мөнгөний зах зээлд: 172,866,538 ₮

Бондод: 160,600,000 ₮

Үнэт цаасны зах зээлийн анхдагч


арилжааны захиалгад: 1,752,317,600 ₮

2022 онд сангийн нэгж эрхийн үнэлгээ 65,912,872 төгрөгөөр өссөн тул нэгж эрхийн үнэ 32,956 төгрөгөөр нэмэгдсэн. Энэ нь хөрөнгө оруулалтын өгөөж өссөнтэй холбоотой.

НИЙСЛЭЛИЙН НОГООН САН

Нийт активын хэмжээ: 102,249,005.81 ₮

2022 оны гүйцэтгэл:



Хугацаатай хадгаламжинд: 101,369,538.87 ₮

Харилцах дансанд: 879,467.94 ₮

2022 онд сангийн нэгж эрхийн үнэлгээ 3,148,981.00 төгрөгөөр өссөн тул нэгж эрхийн үнэ 31,490.00 төгрөгөөр нэмэгдсэн. Энэ нь урт хугацааны хөрөнгө оруулалтын өгөөж орж ирсэнтэй холбоотой.



САНГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛ

НИЙСЛЭЛИЙН ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ САН

Нийт активын хэмжээ: 505,509,532.05 ₮

2022 оны гүйцэтгэл:



Хугацаатай хадгаламжинд: 505,420,501.21 ₮

Харилцах дансанд: 89,030.84 ₮

2022 оны байдлаар сангийн нэгж эрхийн үнэлгээ 2,342.76 төгрөгөөр өссөн бөгөөд энэ нь сангийн хөрөнгийг үр өгөөжтэй ашиглан зарцуулсантай холбоотой.

НИЙСЛЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН САН

Нийт активын хэмжээ: 502,604,273.00 ₮

2022 оны гүйцэтгэл:



Харилцах дансанд: 34,972,765.24 ₮

Хадгаламжийн дансанд: 41,631,507.46 ₮

ТиДиБи лизинг бондонд: 106,410,461.82 ₮

Бичил Глобус бондонд: 352,285,628.49 ₮

2022 оны жилийн эцсийн байдлаар сангийн нэгж эрхийн үнэлгээ 10,356.0 төгрөгөөр буурсан байгаа нь хөрөнгө оруулсан бондын хугацаа дуусаагүй, эргэн төлөлт болон хүүгийн төлбөр орж ирээгүйтэй холбоотой



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
МЕНЕЖМЕНТ УЦЦ ХХК

II БҮЛЭГ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ





ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТУЗ нь аудитын, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын гэсэн 3 хороотойгоор хөрөнгийн зах зээлд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, зааварын хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажиллаж байна.



Тайлант хугацаанд НИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 86 дугаар тогтоолоор ТУЗ-ийн хараат бус гишүүн З.Бямбажав чөлөөлөгдөн Б.Үүрцайхбаатар хараат бус гишүүнээр томилогдсон.

ТУЗ-ийн 2022 оны хурлын мэдээлэл


ТУЗ 4 УДАА ХУРАЛДАЖ 16 АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭСЭН





КОМПАНИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 02/04 дугаар тогтоолоор бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэн 3 газар, 1 алба, 20 орон тоотой батлагдсан бөгөөд 2022 оны эцэст 12 ажилтаны бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.






НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
МЕНЕЖМЕНТ УЦЦ ХХК



БҮЛЭГ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН






ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЙЛАН

КОМПАНИЙН 2022 ОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН



ХҮНИЙ НӨӨЦИЙН ЭРГЭЦ



ХҮИСИЙН ХАРЬЦАА



АЖИЛЛАСАН ЖИЛИЙН БАЙДАЛ

Ажилласан жил	Ажилтны Тоо	Харьцаа
1 жил хүртэл	7	58%
1-2 жил	0	0%
2-с дээш жил	5	42%

ХҮҮХЭД АСРАХ ЧӨЛӨӨТЭЙ 2





ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны



145 дугаар
ТОГТООЛ




276 дугаар
ТОГТООЛ



11 баримт
бичиг

Засаглалын кодексийн 9 зарчмуудын хүрээнд хэрэгжилтийн тайлан гарган ТУЗ-д хүргүүлсэн бөгөөд засаглалын өөрийн үнэлгээг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хийж гүйцэтгэн, үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга хянаж баталсан.

ЗАСАГЛАЛЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН





ТОГТВОРТОЙ БАЙДАЛ-БОНЗ

НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУД

Монгол улсын тогтвортой хөгжлийн дараах зорилгуудын хүрээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг дараах 3 сан дэмжин ажилладаг.

ХӨГЖЛИЙН САН



НОГООН САН



ГАРААНЫ САН



“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО” НЭЭЛТЭЙ ӨДӨРЛӨГ

2022.09.10-ны өдөр Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар, Гадаад харилцааны яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Нийслэлийн ЗДТГ, МҮХАУТ хамтран зохион байгуулсан “Тогтвортой хөгжлийн зорилго” нээлттэй өдөрлөгт амжилттай оролцсон.



Компаниас гарч буй цаасны хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах, багасгах буюу 3R-г хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд өдөр тутамдаа хэрэглэдэг олон төрлийн хэвлэх төхөөрөмжийг олон үйлдэлт нэг хэвлэх машинаар солих, ашиглагдсан цаасуудыг нэгтгэн ноорог цаасны хайрцаганд байршуулах, цаасыг 2 талаар нь хэвлэх зэрэг түршлага, дадлуудыг нэвтрүүлсэн.



Компаний эрчим хүчийг хэмнэхэд анхаарч, барилгын дулаан алдагдлыг бууруулж, өдөр бүр ажлаас тарахад цахилгаан хэрэгсэл, өрөөнүүдийн гэрэл, уртасгагч, залгуур зэргийг унтрааж салгасан эсэхийг хянах хяналтын хуудсыг боловсруулж, бүртгэлжүүлжсэн.





САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН САН

1. “ОУ-ын худалдаа ложистикийн төв гаалийн хяналтын бүс” төсөл
2. “Багахангайн махны үйлдвэр”-ийн төсөл
3. “Нийслэлийн засаг захиргааны IV байрыг засварлах, менежментийг сайжруулах” төсөл
4. “Улаанбаатар хотын эрсдэлийн менежментийг сайжруулах” төсөл
5. Авто замын сан – хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах
6. “Нийтийн тээврийн парк шинэчлэлт”-ийн төсөл
7. “Төв цэнгэлдэх хүрээлэн”-ийн менежментийг сайжруулах төсөл
8. “Зүүн бүсийн худалдаа ложистикийн төв”-ийн төсөл
9. Авто зогсоолын менежментийг сайжруулах төсөл

НИЙСЛЭЛИЙН ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ САН


- | | |
|---|--|
| 1. Цахилгаан автомашин цэнэглэх төхөөрөмж | 10. THRIFT MARKET LLC |
| 2. Цахилгаан халаагуур | 11. Рубик Эй Ай |
| 3. Rubick AI үл хөдлөх хөрөнгийн апп | 12. Хонмоно комик |
| 4. Кофены шаарыг дахин боловсруулах | 13. ЦАГААН УУЛ ТӨГӨЛ ХХК мод үрээллийн төсөл |
| 5. METACOG | 14. КОФЕ ШИГ-Кофены үр савлаж зарах |
| 6. 8X100 боловсролын төв | 15. CENTRAL RICH халаагуур |
| 7. Шимт боловсрол | 16. Янзтай ясны шөл |
| 8. АСН | 17. AIREE агаар цэвэршүүлэгч |
| 9. Chatbot | |

НИЙСЛЭЛИЙН НОГООН САН

1. “ТЭРБУМ МОД” аяны хүрээнд хэрэгжүүлсэн төсөл
2. “СНIP МОНГОЛ ГЭРИЙН ХАЛААЛТ, ДУЛААЛГЫН БАГЦ” төсөл

Судлагдсан төсөл болон санхүүгийн хэрэгслийн харьцаа

■ ННС ■ НХС ■ НГБДС ■ НЭУС



НИЙСЛЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН САН

- | | |
|---------------------|-----------------------|
| 1. Номин бонд | 8. Говь бонд |
| 2. Монложистик бонд | 9. ТиДиБи бонд |
| 3. GSB бонд | 10. Бичил Глобус бонд |
| 4. Соно бонд | 11. Нет капитал бонд |
| 5. БэрС ХБҮЦ | 12. Альфа бонд |
| 6. ТБФинанс бонд | 13. Хүннү бонд |
| 7. Эко нар бонд | |





НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН САНГААС СУДАЛСАН ТӨСЛҮҮД

“ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА ЛОЖИСТИКИЙН ТӨВ” / ГААЛИЙН ХЯНАЛТЫН БУС/ ТӨСӨЛ

2021.09.16

Хамтарсан ажлын хэсэг байгуулагдан, судалгааны ажил эхэлсэн.

2022.10 сар

50 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай хөрөнгө оруулах боломжит судалгааг боловсруулан ХОС-аас төсөлд ТЭЗҮ хийх 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын загварчлалыг ОУХЛТөвд танилцуулсан.

2022.11 сар

Дэд бүтцэд 7.3 тэрбум төгрөгийг Нийслэлийн 2023 оны төсөвт тусгасан.


2022.11-12

БНХАУ-ын Beejing Railway Land Bridge, Mon logistics holding LLC-д төслийг танилцуулсан.





“БАГАХАНГАЙН МАХНЫ ҮЙЛДВЭР”-ИЙН ТӨСӨЛ



- 2022.10.12 Багахангайн махны үйлдвэрийн тухай судлан өмчийн харилцааны газартай уулзсан. Өмчийн харилцаанаас эхний мэдээлэл авсан.
- 2022.10.12 Багахангайн махны үйлдвэртэй танилцан үйлдвэрийн тухай танилцуулга гаргасан.
- 2022.10.12 ХХБ-тай уулзалт хийн бичиг баримтыг хүлээн авсан бөгөөд мах боловсруулах үйлдвэрийн зээлийн барьцаанд бүтээмжлэх үеийн холбогдох баримт бичгийг хүсэлт илгээж хүлээн авсан.
- 2022.10.12 Барилга болон тоног төхөөрөмжийн одоогийн нөхцөлд үнэлгээ хийлгүүлсэн. Үнэлгээгээр дараах дүгнэлт гарсан. Үүнд:
- ✓ Технологийн дагуу баригдаагүй
 - ✓ Хараал хамгаалалт муу учир Тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл нь тоногдсон,
 - ✓ Үйлдвэрийн ашиглалт 3-30% муу
 - ✓ Дэд бүтэц нь тоногдсон
 - ✓ Барилгыг сэргээх засвар үйлчилгээний зардал өндөр
 - ✓ 2020 онд Менежментийн гэрээгээр 2 удаа тендер зарласан боловч тендерт шалгарсан ААН байхгүй
 - ✓ УБ хотод агуулахын объект байсан нь дуудлага худалдаагаар зарагдсан
 - ✓ “Багахангайн мах боловсруулах үйлдвэр” НӨҮГ одоогоор 4 хүний орон тоотой жил бүр 2020-68 сая, 2021- 67 сая, 2022 оны 66 сая төг Нийслэлийн төсөвт тусуулан ажиллаж явсаар ирсэн.



НИЙТИЙН ТЭЭВРИЙН ПАРК ШИНЭЧЛЭЛ



НЗД-ийн 2022.02.17 - А/190 2022.07.01- А/967
захирамжууд гарсан

Судалгаа, шинжилгээ хийн , схем боловсруулсан.

НЗД зөвлөлийн хуралд 2022.04.13-ны өдөр
танилцуулсан.

НИТХ болон Засгийн газарт танилцуулсан.
НИТХ-ын 2022.05.30 51 дүгээр тогтоол гарсан

2022 онд 224 дизель хөдөлгүүртэй их багтаамжийн
автобусаар нийтийн тээврийн парк шинэчлэл
хийгдсэн.



“НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ IV БАЙРЫГ ЗАСВАРЛАХ, МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ



2022 оны
1-р улиралд

Нийслэлийн засаг захиргааны IV байр болон түүнд нийслэлийн бонд гаргах судалгаа хийн УБХХ-ийн корпорацид танилцуулсан.

2022 оны
2-3-р
улиралд

ХБҮЦ гаргах ажилд хамтран ажиллах хүсэлтийг УБХХ-ийн корпорацид өгсөн. Нийслэлийн бонд гаргах судалгааны үр дүнг дахин танилцуулсан.

2022 оны
4-р
улиралд


Төслийг НЗД-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн УБХХ-ийн корпораци ТХХТ-ээр хэрэгжүүлэх шийдвэр гарсан. Үүнтэй холбоотой УБХХ-ийн корпораци менежментийн эрх шилжүүлэх сонгон шалгаруулалт зарласан.

4-Р БАЙРНЫ МЭДЭЭЛЭЛ:

- Нийт талбай: 9,614.5 м.кв
- Нийт ашигтай талбай: 5,808.1 м.кв /шинэчлэх шаардлагатай/
- Бүртгэлийн үнэлгээ: 7.4 тэрбум /баланс дээрх/



“УЛААНБААТАР ХОТЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ



2022 оны 3-р улиралд


Нийслэлийн өмчийн харилцааны газартай санал солилцон хамтарч ажилласан.

Хөрөнгө оруулалтын сангаар дамжуулан Нийслэлийн эзэмшлийн хувьцааны хувийг нэмэгдүүлж, менежментийг сайжруулж, даатгалын нөөц сангийн хөрөнгийг удирдах боломжийг судласан.

2022 оны 4-р улиралд

Улаанбаатар хотын даатгалын удирдлагуудтай уулзалт хийж компанийн 51%-ийн үнэлгээний үнийн санал авсан.

Нийслэлийн өмчийн ашиглалтыг сайжруулахын тулд шаардагдах хөрөнгө оруулалтын тодорхой хувийг нийслэлийн төсөвт тусгуулах талаар шийдвэр гаргуулах зорилготойгоор Нийслэлийн засаг даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.





АВТО ЗАМЫН САН - ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ГАРГАХ

Хөрөнгө оруулах чиглэл: Сангийн активыг нэмэгдүүлэх

Ирээдүйн авто замын санд төвлөрөх мөнгөн үрсгал, орлогыг санхүүгийн бүтээгдэхүүн (хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас) гаргах замаар хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлж шаардлагатай зам, гүүрийн бүтээн байгуулалтыг хийх боломжийг судалсан.

Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээний хүрээнд нэвтрүүлж буй RFID системийг нэвтрүүлэх бэлтгэл ажил бүрэн хангагдсан.

Систем нэвтэрснээр Авто замын сангийн орлого 2 дахин өсөх судалгаа, тооцоолол гарсан.

Ирээдүйд бий болох мөнгөн үрсгалын орлогыг үнэт цаасжуулж, 300-500 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт босгох боломжтой.

Авто замын сангийн орлого нь төсвийн орлогын бүрэлдэхүүн бөгөөд Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийг бүрдүүлж, орлогыг бүтээн байгуулалттай холбоотой төсөл хөтөлбөрт зарцуулах, мөн үнэт цаас гаргах зэрэг эрхтэй.

Төсвийн захирагч нь төсвийн бүрэлдэхүүн болох төсвийн сангийн орлогыг барьцаалах, түүгээр баталгаа гаргаж болохгүй гэсэн заалтыг дараах байдлаар өөрчлөх;

Авто замтай холбоотой томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг Холбогдох хуульд нийцүүлэн зөвшөөрсөн заалт оруулах нь зөв.

Төсвийн хуульд өөрчлөлт оруулах тул зөвхөн авто замын сан биш бусад

- тусгай зориулалтын сангуудын хувьд орлогыг барьцаалах,
- баталгаа гаргах талаар эрх олгох тухай заалт оруулах шаардалгатай.



ТЭРБУМ МОД АЯНЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ

2022.03 сар

Нийслэлийн зорилт 120 сая мод тарих аяны хүрээнд мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхэлдэг ААН-д хөрөнгө оруулалт хийх боломжийг судлаж эхэлсэн.

2022.03 сар

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг Нийслэлд зохион байгуулах “Ногоон хот, иргэний оролцоо” зөвөлгөөнд УБ хотын Нийслэлийн Ногоон сан оролцсон.

2022.04 сар

Мод үржүүлгийн мэргэжлийн холбоод, Нийслэлийн байгаль орчны газартай хамтарсан уулзалтуудыг хийсэн.

2022.07 сар

Мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 200 гаруй байгууллагаас хамтран ажиллах хүсэлт ирүүлсэн бөгөөд 9 компанийн төслийн судалгааны ажлыг эхлүүлэн UBT Garden компанийг сонгон нарийвчилсан судалгааны ажлыг эхлүүлсэн.

2022.08-11 сар

ННС-ын бодлогын баримт бичгийн 2.3 дугаар хэсэгт заасны дагуу үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулах боломжгүй тул компанийн хувьцаанд хөрөнгө оруулах боломжийг судлахаар нарийвчилсан судалгааг үргэлжлүүлсэн. Тус байгууллага хувьцааг худалдах боломжгүй гэж хариу мэдэгдсэнээр 2022 оны 11 сард тус төсөл хаагдсан





“CHIP МОНГОЛ ГЭРИЙН ХАЛААЛТ, ДУЛААЛГЫН БАГЦ” ТӨСӨЛ

Хөрөнгө оруулах чиглэл: Орчны бохирдлыг бууруулах

№	ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ	ТАЙЛБАР
1	Санхүүжүүлэгч байгууллага	НҮБ-ийн Хүүхдийн Сан, Швейцарын хөгжлийн агентлаг
2	Үндсэн зохицуулагч байгууллага	“People In Need” ТББ
3	Дэмжин хэрэгжүүлэгч байгууллага	ШУТИС, ТОС холбоо
4	Хөрөнгө оруулалтын өгөөж	8%
5	Иргэдэд олгох зээлийн хүү	18%
6	Төслийн эргэн төлөгдөх хугацаа	12 сар

Уг төслийн хувьд:

- Дулаан алдагдлыг 40% бууруулдаг
- Нүүрсний утаа, хог, үнс гаргахгүй
- Цаг хугацаа хэмнэнэ
- Ил галаас үүдэлтэй галын аюулгүй
- Дотоод орчны агаар сайжирна
- Цэвэрхэн, тохь тухтай

зэрэг давуу талуудтай бөгөөд Австралийн South Pole Consulting –аас гаргасан аргачлалаар эрчим хүчний хэмнэлтийг тооцоход өндөр үр дүнтэй мөн БОАЖЯ-ны ногоон бүтээгдэхүүний жагсаалтад багтсан, Нийслэлийн ногоон сангийн **үйл ажиллагааны чиглэлтэй нийцэж** буй төсөл (хүлэмжийн хий бууруулах, агаар орчны бохирдлыг бууруулах) байсан тул хөрөнгө оруулалтыг хийж гүйцэтгэсэн.

2022 оны 12 сарын байдлаар нийт 887 Чип багц нийлүүлэгдсэн ба үүнээс 3906 хүн ашиг хүртэж байна.

Үүнд:



- Хүүхэд-1206
- Ахмад настан-434
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн-62
- Жирэмсэн эх-34
- Өрх толгойлсон эцэг, эх-226

2022 оны 12 сард хөрөнгө оруулалтын хугацаа дуусч буй бөгөөд дахин хөрөнгө оруулалт хүсэн холбогдох материалыг илгээхээр хүлээгдэж байна.



ТХХТ-ЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

“СЭЛБЭ ГОЛЫН ЭРГИЙН ТОХИЖИЛТ”-ИЙН ТӨСӨЛ

Хөрөнгө оруулах чиглэл: Төр хувийн хэвшлийн түншлэл

- 2020 оны 12 сарын 11-ний өдөр байгуулсан “Төсөл хамтран хэрэгжүүлэх гэрээ”-ний дагуу “Сэлбэ Урбан Парк” ХХК-ийг Нийслэлийн Өмчит Улаанбаатар Хөрөнгө Оруулалт Менежмент ҮЦК ХХК GO&TS ХХК хамтран байгуулсан.

Хувьцаа эзэгшигч	Эзэмшлийн %	Үнийн дүн
“НӨУБХОМК ҮЦК” ХХК	10%	100.000₮
“ЖИ ӨҮ ЭНД ТИ ЭС” ХХК	90%	900.000₮

- 2022 оны 3 сарын 18 өдөр “Сэлбэ Урбан Парк” ХХК-ийн ТУЗ-ын хурал хийгдсэн бөгөөд тус хурлаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төслийн гүйцэтгэлийг хэлэлцсэн.
- 2022 оны 6 сарын 16-нд хөрөнгө оруулагч талаас төсөлд хөрөнгө оруулахад нөхцөл байдал хүнд байгаа тул гэрээг цуцлах хүсэлт ирүүлсэн ба ЗГ-ийн тогтоолоор БНХАУ-ийн 1 тэрбум ам долларын зээлийн хүрээнд хийгдэх ажлын жагсаалтанд Сэлбэ голын эргийн тохижилтын ажил 3 сая ам долларын санхүүжилттэй тусгагдан Засгийн газрын тогтоолын дагуу Нийслэлд төслийн нэгж 2022 оны 10 сард үүсэн “Төсөл хамтран хэрэгжүүлэх гэрээ”-ний 8.1.2-д үндэслэн гэрээг цуцалж, хамтарсан компанийг компанийн тухай хуулийн 26, 27, 28, 29-р зүйлээр татан буулгахаар шийдвэрлэсэн.

СЭЛБЭ ПАРК

АНУ-БНХАУ ГУДАМЖ

Мх тойруугийн гүүр болон Бээжингийн гудамжны гүүр хооронд орших Сэлбэ голын далайд Америкийн Нэгдсэн Улс болон Бүгд Найрамдах Хятад ард улсын Төрөөр тохижуулж, дугуйн болон гүйтийн замтай байгаар төлөвлөв. Энэ хэсэгт тухайн улс орнуудын түүхийн дурсгалт баримт байгууламжуудыг оруулсан болно.

ЭНЭТХЭГ-ФРАНЦЫН ГУДАМЖ

Бээжингийн гудамжны гүүр болон Арслантай гүүр хооронд орших Сэлбэ голын далайд Энэтхэг болон Франц улсын төрөөр тохижуулж, дугуйн болон гүйтийн замтай байгаар төлөвлөв. Энэ хэсэгт тухайн улс орнуудын түүхийн дурсгалт баримт байгууламжуудыг оруулсан болно.

МОНГОЛ-ОРОСЫН ГУДАМЖ

Арслантай гүүр болон Натугийн гүүр хооронд орших Сэлбэ голын далайд Монгол болон Орос улсын төрөөр тохижуулж, дугуйн болон гүйтийн замтай байгаар төлөвлөв. Энэ хэсэгт тухайн улс орнуудын түүхийн дурсгалт баримт байгууламжууд, үндэсний шинэ төрлийн агуулсан байгууламжууд, ЗЭЗ сэгсэн бөмбөгний талбай, задгай талбайг оруулан төлөвлөж болно.

СОЛОНГОСЫН ГУДАМЖ

Натугийн гүүрийн орчимд орших Сэлбэ голын далайд Солонгос тухайн улс орны түүхийн дурсгалт баримт байгууламжууд, Саруул хотхоны гүүр хүртэл дугуйн болон гүйтийн зам, нэрдэгдүүлэх талбай, хүүхдийн тоглоомын талбай зэргийг төлөвлөв.




ТХХТ-ЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД


“ТУУЛ ГОЛЫН ЭРГИЙН ТОХИЖИЛТ”-ИЙН ТӨСӨЛ

Хөрөнгө оруулах чиглэл: Төр хувийн хэвшлийн түншлэл

- 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр “Туул голын эргийн тохижилт” төслийн хүрээнд
- Төсөл хамтран хэрэгжүүлэх гэрээ
- Хувьцаа эзэмшигчдийн гэрээг байгуулсан.
- Тус ажлын хүрээнд 2020-2021 онд ажлын хэсэг удаа дараа хуралдан төсөл хэрэгжүүлэх гэрээ, компани үүсгэн байгуулах тогтоол гаран хамтарсан компани үүсгэн байгуулагдсан.



2022 онд Усны газар, Экологийн цагдаагийн алба, УСУГазар болон БХБЯам-ны захиалгаар үерийн хамгаалалтын далангийн ажлын зураг тендерт шалгарсан Хайдро прожект ХХК-тай хамтран үулзалт хийн төслийн судалгааг гүйцэтгэсэн бөгөөд 2023 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулсан.



Тус төсөл хэрэгжих 149.2 га газар нь Улаанбаатар Хөрөнгө Оруулалт Менежмент ҮЦЦ ХХК-ийн нэр дээр гарсан бөгөөд төсөл хамтран хэрэгжүүлэгчээс газрын эзэмших эрхийг хамтарсан компани болох Туул урбан парк ХХК-д шилжүүлэх санал тавьсан бөгөөд холбогдох хууль эрх зүйн хүрээнд Нийслэлийн өмчийн харилцааны газартай хамтран ажиллаж, Засаг даргын зөвлөлийн хурлаар газар эзэмших эрх шилжүүлэх талаар танилцуулж, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажил хангасан.



ТХХТ-ЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

“ЦАГИЙН ХЯЗГААРТАЙ АЖИЛЛАХ АВТОМАШИНГҮЙ ГУДАМЖ” ТӨСӨЛ


2021.06.24 НЗД-ын А/501 захирамж

“Чойжин ламын сүм музей”,
“Урт цагааны гудамж”,
“Үндэсний соёл амралтын хүрээлэн” 3 газар сонгосон

Тохижилтын ажлын скийз зураг гарган 2022.09.15-нд Нийслэлийн
Хот байгуулалт Хөгжлийн газраар батлуулсан.

Тохижилтын ажлын скийз зураг гарган 2022.09.15-нд
Нийслэлийн Хот байгуулалт Хөгжлийн газраар батлуулсан.

Рио Тинто Монгол ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд ногоон
байгууламж бүхий тохижилтын ажлыг хийхээр Нийслэлийн засаг
даргатай хамтран ажиллах гэрээ байгуулсан тул төслийг
зогсоосон.





ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО



Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх дараах баримт бичгүүдийг боловсруулж баталсан.

- ✓ “Эрсдэл ба боломжийг удирдах журам”
- ✓ “Үйл ажиллагааны эрсдэлийн журам”

Үйл ажиллагааны эрсдэлийг үнэлгээ хийж тус эрсдэлүүдийг 24%-иар бууруулан ажилласан.



Хууль, дүрэм журмын нийцэл, хэрэгжилтийг хангуулах хяналтын дараах баримт бичгүүд боловсруулж баталсан.

- ✓ “Комплайнсын үйл ажиллагааны журам”
- ✓ “Хяналтын хуудас”
- ✓ “Комплайнсын хөтөлбөр”

Дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх дараах баримт бичгүүдийг боловсруулж баталсан.


- ✓ “Дотоод хяналтын үйл ажиллагааны журам”
- ✓ “Дотоод аудитын журам”
- ✓ “Үл тохирлын журам”

ЭРСДЭЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Эрсдэлийн зөвлөл нь дараах 3 агуулгын хүрээнд 7 удаа хуралдаж 10 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

- ✓ Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа
- ✓ Сангийн мөнгөн хөрөнгийн үйл ажиллагаа
- ✓ Эрсдэлийн зөвлөлийн үйл ажиллагаа

Хяналт, шалгалт





ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА



Монгол дахь
Америкийн
Худалдааны Танхим
/AMCHAM



Стартап маркетинг спэйс
/SMS/, START

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА



Asia Securities Industry & Financial
Markets Association



2022 оны 10 дугаар сард Герман, Нидерланд улсад зохион байгуулагдсан Тогтвортой Санхүүжилтийн чиглэлээр туршлага судлах аялалд бусад санхүүгийн байгууллагуудтай хамтран оролцлоо.

НИЙСЛЭЛИЙН АЖЛЫН ХЭСЭГ

A/190 Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах хүрээнд цахилгаан хөдөлгүүртэй автобусаар парк шинчлэлт хийх, багтаамж ихтэй тээврийн шинэ төрөл нэвтрүүлэх тооцоо, судалгааг хийж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах

A/276 Нийслэл Улаанбаатар хотын Үнэт цаас гаргах, арилжаалах, бүртгэх, төлбөр хийх, төвлөрүүлсэн хөрөнгийг захиран зарцуулахтай холбоотой эрх зүйн орчныг судалж, үнэт цаас гаргах бэлтгэл ажилтай холбогдуулан санал, дүгнэлт гаргах

A/601 Олон улсын худалдаа логикийн төв ХК-ийн төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн талаар тооцоо, судалгаа хийж санал, дүгнэлт боловсруулах

A/812 "Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-ний төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах

A/967 Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг өууруулах, нийтийн тээврийн парк шинэчлэх ажлын хүрээнд дизель, цахилгаан хөдөлгүүртэй шинэ автобус нийлүүлэгчийг сонгон шалгалуурах

A/1142 НАМА Фасилити байгууллагын буцалтгүй тусламжийн эх үүсвэр болон нийслэлийн төсвийн хөрөнгөөр Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлэх "Угсармал орон сууцны барилгуудын дулаан алдагдлыг бууруулах төсөл"-ийн хүрээнд нийслэлийн оролцоо, чиг үүргийг тодорхойлох, төслийн бэлтгэлийн үе шатны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, зохион байгуулалтаар хангаж ажиллах



ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ

Нийслэл дэх Төрийн аудитын газрын шийдвэрээр сонгогдсон Нийслэл Аудит ХХК нь гэрээний дагуу компанийн 2020, 2021, 2022 онуудын санхүүгийн тайланд аудит хийж ажилласан. Уг аудитаар өөрчлөлтгүй гэсэн дүгнэлт гарсан.

